



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/361/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Утас: 51-261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: В.Эрдэнэцогт

Утас: 323266 Цахим хаяг: [erdenetsogtv@audit.gov.mn](mailto:erdenetsogtv@audit.gov.mn)

Ахлах аудитор: М.Пагамдулам

Утас: 323266 Цахим хаяг: [pagmadulam@audit.gov.mn](mailto:pagmadulam@audit.gov.mn)

Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн захирал:

Д.Баатарсайхан

Утас: 99099119 Цахим хаяг: [gerelthuhaudit@gmail.com](mailto:gerelthuhaudit@gmail.com)

Улаанбаатар хот  
2026 он

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Ж.ОТГОНБААТАР ТАНАА

2026.03.10 № 06/575  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,932,836.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар 1,281,028.7 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн үйлдвэр болон тоног төхөөрөмжийг орлогод авсан боловч ашиглалтад оруулаагүй, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй;
- Нэгдсэн үндэсний хүүхдийн сангаас санхүүжүүлсэн Хүүхдийн дүрс оношилгооны чадавхыг бэхжүүлэх сургалт, Хүүхдийн зүрхний олдмол гажгийг оношлох эмч бэлтгэх, зүрхний хэт авайн оношилгооны чадамж олгох сургалт, Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийг орон нутагт илрүүлэх багийн ажиллагаа үзлэг сургалтуудад, нийт 226,832.4 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод тооцоог хийж, зарцуулалтыг тайлагнаагүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцээгүй.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн амбулаторийн барилга шинээр ашиглалтад орсноор эх, хүүхдэд үзүүлэх эмчилгээний төрөл, хүртээмж өргөжсөн бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 421 дүгээр тушаалыг үндэслэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 171 дүгээр тушаалаар Хүүхдийн мэдрэлийн мэс заслын тасгийг шинээр байгуулж, 19 хүүхдэд хагалгаа хийсэн нь амжилттай болсон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өндөр өртөгтэй элэг шилжүүлэн суулгах мэс засал, бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг Нэгдүгээр эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын багтай хамтран Монгол улсад анх удаа 6 хүүхдэд амжилттай хийж, эм, лабораторийн шинжилгээний зардалд 397,272.3 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар эмч, эмнэлгийн ажилчдын цалинг 6 хувь буюу 9,222,075.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч цалингийн санг нэмж тодотгоогүйгээс жилийн эцэст 8,079,360.4 мянган төгрөгийн цалин, татвар, шимтгэлийн өртэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ